



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 4/322

Арвайхээр сум

### Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах тухай" 01 дүгээр албан даалгавар, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрч зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах арга хэмжээг эрчимжүүлэх, сумын онцгой комисст дэмжлэг үзүүлж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамжид заасан арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн дотор хэрэгжүүлж, зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг Аймгийн онцгой комисст ирүүлж, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа) болон сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, Хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.СУМЬЯАСҮРЭН

6224 11 0664

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дүгээр  
сарын 23-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

Аймгийн хэмжээнд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг  
устгах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр ажиллах тухай

**Нэг: Зорилго**

Энэхүү удирдамжийн зорилго нь Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 02 дугаар  
сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2024 оний 04 дүгээр сарын  
18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайдын 2024 оны 03 дугаар сраян 22-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хүрээнд  
өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг цуглуулах,  
устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх халдвартайгэх, мал,  
амьтны гоц халдварт өвчний дэгдэлтийг зогсоох, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх  
ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, мэргэжил  
арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллийг шуурхай солилцоход оршино.

**Хоёр. Ажиллах баг, хугацаа, газар**

1. Нэгдүгээр ажлын хэсэг: Баянгол, Сант сум

Засаг даргын орлогч: О.Сумьяасүрэн

Жолооч: Г.Амаржаргал

2. Хоёрдугаар ажлын хэсэг: Зүүнбаян-Улаан, Уянга сум

Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа: Д.Одонбаяр

Мал эмнэлгийн яналтын улсын байцаагч: Б.Ариунцэцэг

Жолооч: Г.Мягмарсүрэн

3. Гуравдугаар ажлын хэсэг: Хархорин, Хужирт сумд

Мал эмнэлгийн газрын дарга: А.Нямдаваа

Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн: А.Энхтүвшин

Жолооч: Б.Жаргалсайхан

4. Дөрөвдүгээр ажлын хэсэг: Баян-Өндөр, Бүрд сумд

Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга: С.Цэдэнбалжир

Мал эмнэлгийн яналтын улсын байцаагч: Ц.Төмөрбат

Жолооч: Ч.Чинзориг

**Гурав. Хугацаа, зардал**

Захирамжаар хуваарилагдсан суманд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 04  
дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл нийт 3 хоног ажиллана.

**Шаардлагатай шатахууны зардал**

Д/д	Ажлын хэсэг	Автомашин	Шатахууны төрөл	Хэмжих нэгж	Үнэ	Явах км	Хэмжээ	Нийт дүн (төгрөг)
1	Сант Баянгол	Ланд 200	ДТ	литр	3500	350	70	245,000

2	ЗБҮ Уянга	Ланд 200	АИ-92	литр	2470	400	80	197,600
3	Хархорин Хужирт	Ланд 76	ДТ	литр	3500	450	68	238,000
4.	Бүрд Баян- Өндөр	Ланд 200	АИ-92	литр	2470	400	80	197,600
Нийт					1600	298	878,200	

### Дөрөв. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1.Сумын онцгой комисс, шуурхай штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шууд удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

1.2.Сумдын онцгой комисс, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

1.3.Малын сэг зэмийг устгах арга хэмжээг 04 дүгээр сарын 29-ний дотор зохион байгуулж дуусгах, нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай хүн хүч хэрэгслийг татан оролцуулах;

1.4.Урьдчилан сэргийлэх халдвартгүйтгэлийн арга хэмжээнд малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанар стандартын шаардлага хангасан, хүн малын эрүүл мэнд, байгальд нөлөөгүй халдвартгүйтгэлийн бодис хэрэглэх; (Мал эмнэлгийн газраас сэг зэм устгалд нийт 19 суманд 245 кг бодис хуваарилсан.)

1.5.Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Мал, амьтны хүүр, сэг зэм устгах үйл ажиллагааны заавар, Мал, амьтны хүүр сэг зэмийг устгах, халдвартгүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 6406:2013 стандартыг мөрдүүлж ажиллах;

1.6.Мал, амьтны сэг зэм устгах нүх нь 10м урт, 4м өргөн, 4м гүн байх бөгөөд (1 нүхэнд 3600 бол малын сэг зэм орно) нүхний амсраас 0,5 метрээс багагүй зай нүхэндээ үлдээж сэг зэмийг хийнэ. Газрын хөрснөөс дээш 1,5 метрээс багагүй шороон овоолго үүсгэж, үндэс бүхий хөрсөөр хучилт хийсний дараа халдвартгүйтгэл хийнэ.

1.7.Булшилж устгасан цэгийн эргэн тойронд хашилага хийн, “АНХААР ХҮН, МАЛ ОРОХЫГ ХОРИГЛОНО” гэсэн анхааруулга тэмдэг байрлуулж, сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгөх;

1.8.Хорогдсон малын мэдээг гаргахдаа сум орон нутагт хорогдсон болон өөр аймаг суманд хорогдсон малын тоог ялгаж өрх, малын төрлөөр гаргаж мэдээлэх;

1.9.Сэг зэмийн устгал хийгдэж байгаа цэг тус бүрийг зураг, бичлэг, газрын зураглалаар гаргаж, илтгэх хуудсаар 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Онцгой байдлын газарт ирүүлэх;

### Тав. Сумдад ажилласан ажлын хэсгийн дүнг танилцуулах

5.1.Ажлын хэсгүүд сумдад ажилласан, авч хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн танилцуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Онцгой комиссын дэргэдэх шуурхай штабт танилцуулах;